



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 8/122

Номгон

Хяналт-шинжилгээ, үнэлгээний
дүнгийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.3, 10.4, 10.6 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумдын Засаг даргын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг нэгдүгээр, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг хоёрдугаар, Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагуудын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг гуравдугаар, аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүдийн 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, сумдын Засаг даргын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 89,19 хувь буюу 4,45 оноо авч, “Тэргүүн” байр эзэлсэн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрыг 12,000,000 (Арван хоёр сая) төгрөгөөр, 85,23 хувь буюу 4,26 оноо авч, “Дэд” байр эзэлсэн Баянговь сумын Засаг даргын Тамгын газрыг 8,000,000 (Найман сая) төгрөгөөр, 78.46 хувь буюу 3.92 оноо авч, “Гутгаар” байр эзэлсэн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрыг 4,000,000 (Дөрвөн сая) төгрөгөөр, 76,30 хувь буюу 3,81 оноо авсан Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар, 75,95 хувь буюу 3,79 оноо авсан

625010374

Богд сумын Засаг даргын Тамгын газрыг “Тусгай” байрт шалгаруулан тус бүр 2,000,000 (Хоёр сая) төгрөгөөр шагнаж, “Батламж” хадгалуулсугай.

3.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 97,71 хувь буюу 4,88 оноо авч, “Тэргүүн” байр эзэлсэн Санхүүгийн хяналт, аудитын газрыг 8,000,000 (Найман сая) төгрөгөөр, 94,71 хувь буюу 4,73 оноо авч, “Дэд” байр эзэлсэн Татварын газрыг 5,000,000 (Таван сая) төгрөгөөр, 93,54 хувь буюу 4,67 оноо авч, “Гутгаар” байр эзэлсэн Орон нутгийн өмчийн газрыг 3,000,000 (Гурван сая) төгрөгөөр, 89,92 хувь буюу 4,49 оноо авсан Хүнс, хөдөө аж ахуйн газар, 89,19 хувь буюу 4,45 оноо авсан Улсын бүртгэлийн хэлтсийг “Тусгай” байрт шалгаруулан тус бүр 1,000,000 (Нэг сая) төгрөгөөр шагнаж, “Батламж” хадгалуулсугай.

4.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 89,4 хувь буюу 4,47 оноо авч, “Тэргүүн” байр эзэлсэн Хууль, эрх зүйн хэлтсийг 3,000,000 (Гурван сая) төгрөгөөр, 87,4 хувь буюу 4,37 оноо авч, “Дэд” байр эзэлсэн Цэргийн штабыг 2,000,000 (Хоёр сая) төгрөгөөр шагнаж, “Батламж” хадгалуулсугай.

5.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 92,76 хувь буюу 4,63 оноо авч “Тэргүүн” байр эзэлсэн “Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа” -г 5,000,000 (Таван сая) төгрөгөөр, 88,15 хувь буюу 4,40 оноо авч, “Дэд” байр эзэлсэн “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨТБ-ыг 2,000,000 (Хоёр сая) төгрөгөөр шагнаж, “Батламж” хадгалуулсугай.

6.Сум, агентлаг, Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагуудын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр “Тэргүүн” байр эзэлсэн сумын Засаг дарга, агентлаг, орон нутгийн өмчийн байгууллагын даргыг 1 сарын үндсэн цалин, “Дэд” байр эзэлсэн сумын Засаг дарга, агентлаг, төрийн өмчийн байгууллагын даргыг 1 сарын үндсэн цалингийн 80 хувиар, “Гутгаар” байр эзэлсэн сумын Засаг дарга, агентлагийн даргыг 1 сарын үндсэн цалингийн 50 хувиар, “Тусгай” байр эзэлсэн сумын Засаг дарга, агентлагийн даргыг 1 сарын үндсэн цалингийн 40 хувиар шагнасугай.

7.Сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага, Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийг шагнасан 59,000,000 (Тавин есөн сая) төгрөг, Батламжийн үнэ 1,500,000 (Нэг сая таван зуун мянган) төгрөг, бүгд 60,500,000 (Жаран сая таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

8."Тэргүүн", "Дэд", "Гутгаар", "Тусгай" байрт шалгарсан сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, холбогдох мэргэжилтэн, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Төрийн болон Орон нутгийн өмчийн газрын холбогдох мэргэжилтнүүдийг хууль тогтоомжийн дагуу шагнаж урамшуулахыг холбогдох агентлаг, Төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын дарга, сумдын Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

9.Сумдын Засаг дарга, агентлаг, орон нутгийн өмчийн байгууллагын дарга нарт олгох шагналыг тухайн байгууллагын төсвөөс зарцуулахыг нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

10.Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 50 хувиас доогуур үнэлгээ авсан Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Төрийн болон Орон нутгийн өмчийн байгууллагуудын үйл ажиллагааг жигдрүүлэх, ажилтан, албан хаагчдын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх цогц арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Эрдэнэбат), холбогдох хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

11.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, сум орон нутагт гарах үр дүн, үр нөлөө, төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлж ажиллахыг бүх шатны төрийн байгууллагын дарга, албан хаагч нарт үүрэг болгосугай.

12.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар
сарын 07-ны өдрийн 1 дугаар
захирамжийн 182 дүгээр хавсралт



СУМДЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

д/д	Сумын нэр	Үнэлгээний хувь	ХШҮ хийх журмын 8.11 дүгээр заалтын нэмэлт оноо	Эцсийн дүн
1	Өлзийт	79.19	10	89.19
2	Баянговь	85.23		85.23
3	Баянцагаан	80.46		78.46
4	Баянхонгор	74.30	10	76.30
5	Богд	75.95		75.95
6	Баянлиг	74.99		74.99
7	Баацагаан	72.45		72.45
8	Хүрээмарал	71.64		71.64
9	Баянбулаг	71.47		71.47
10	Эрдэнэцогт	71.30		71.30
11	Баян-Өндөр	71.10		71.10
12	Шинэжинст	68.47		68.47
13	Жаргалант	66.73		66.73
14	Баян-Овоо	66.33		66.33
15	Бууцагаан	66.32		66.32
16	Заг	63.07		63.07
17	Бөмбөгөр	59.03		59.03
18	Жинст	52.82		52.82
19	Гурванбулаг	43.19		43.19
20	Галуут	40.96		40.96

___оОо___

Аймгийн Засаг даргын 9088 оны 03 дугаар
сарын 07-ны өдрийн 12 дугаар
захирамжийн 123 дугаар хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
АГЕНТЛАГУУДЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ДҮН

Д/д	Байгууллагын нэрс	Үнэлгээний дүн
1	2	3
1	Санхүүгийн хяналт, аудитын газар	97.71
2	Татварын газар	94.71
3	Орон нутгийн өмчийн газар	93.54
4	Хүнс, хөдөө аж ахуйн газар	89.92
5	Улсын бүртгэлийн хэлтэс	89.19
6	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	88.95
7	Нийгмийн даатгалын газар	87.43
8	Мал эмнэлгийн газар	86.83
9	Статистикийн хэлтэс	85.4
10	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	84.04
11	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	83.84
12	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	82.44
13	Эрүүл мэндийн газар	81.36
14	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	80.42
15	Боловсролын газар	79.28
16	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	78.43
17	Шүүх шинжилгээний хэлтэс	77.52
18	Байгаль орчны газар	77.26
19	Цагдаагийн газар	77.04
20	Биеийн тамир, спортын газар	75.84
21	Онцгой байдлын газар	75.7
22	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	75.15
23	Худалдан авах ажиллагааны газар	59.71
24	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	40.95

___оОо___

Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар
сарын 07-ны өдрийн 4 дугаар
захирамжийн 192 дугаар хавсралт




ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ДҮН

Д/д	Байгууллагын нэр	Ерөнхий үнэлгээ
1	Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	92.76%
2	Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТБ	88.15%
3	Цэвэр хот ОНӨААТҮГ	84.64%
4	Баянхонгор Эрчим хүч ЦТХХК	83.48%
5	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци ОНӨҮГ	82.73%
6	Чандмань-Баянхонгор ХК	81.08%
7	Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	80.74%
8	Жаргалтай амьдрал сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төв	79.04%
9	Сум дундын ойн анги	64.24%
10	Баянхонгор аймаг Автотээврийн төв	48.42%
11	Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	12.42%

___оОо___

Аймгийн Засаг даргын 1095 оны 03 дугаар
сарын 07-ны өдрийн 4 дугаар
захирамжийн 189 дүгээр хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЭЛТСҮҮДИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ДҮН

д/д	Хэлтсийн нэр	Ерөнхий үнэлгээ
1	Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс	91,03
2	Хууль, Эрх зүйн хэлтэс	89,4
3	Цэргийн штаб	87,4
4	Нийгмийн бодлогын хэлтэс	84,91
5	Санхүү, төрийн сангийн хэлтэс	84,89
6	Залуучуудын хөгжлийн төв	84,5
7	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	83,21
8	Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс	80,60

___оОо___

